

МӨРИЙТЭЙ ТОГЛООМ ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ЗҮЙЛЧЛЭЛИЙН АСУУДАЛ

ORGANIZING GAMES OF RANGE PROBLEMS OF CRIMINAL BEHAVIOR

Б.Батцэрэн

*ДХИС-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
ахлах багш, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг нь дэлхий дахин болоод Монгол улсад шинэ ойлголт биш бөгөөд Монгол Улс хэд хэдэн Эрүүгийн хуульдаа энэ төрлийн гэмт хэргийг тусгаж өгсөн байдаг. Харин хэсэг хугацаанд уг ойлголтыг эрүүгийн хуулиар хориглоогүй, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрч байсан ба 2015 онд батлагдан гарч 2017 оны 07 дугаар сарын 01-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн мөрийтэй тоглоом зохион байгуулах үйлдлийг эрүүжүүлсэн нь практикт тус гэмт хэргийг зүйлчлэх хэрэгцээ шаардлага гарч ирсэн.

Abstract: The crime of organizing gambling is not a new concept in the world and in Mongolia, and Mongolia has included this type of crime in several Criminal Laws. However, for some time, the concept was not prohibited by the criminal law, it was accepted to operate on the basis of a special license, and with the amendment of the law approved in 2015 and effective from July 1, 2017, from January 10, 2020 From the criminalization of gambling and the organization of gambling, the need to criminalize the crime has arisen in practice.

Түлхүүр үгс: Мөрийтэй тоглоом зохион байгуулах, казино, Chance-based /Тохиолдлын шинжтэй буюу азад суурилсан/, Skill-based /Ур чадварт суурилсан/

Keywords: Organization of gambling, Casino, Chance-based, Skill-based

Мөрийтэй тоглоомыг зохицуулах эрх зүйн зохицуулалт нь уламжлалт хэв маягаар олон жил явж ирсэн боловч сүүлийн 20 гаруй жил интернэт, харилцаа холбооны хэрэгслүүд хурдацтайгаар хөгжиж байгаа энэ үед олон оронд ээдрээтэй бий байдлыг бий болгож, хууль тогтоогчдыг хэцүү байдалд оруулж байгаа нь үнэн юм. Өөрөөр хэлбэл, мөрийтэй тоглоомыг интернэтээр, орон зай, цаг хугацаа харгалзахгүйгээр тоглох боломж бий болж, мөрийтэй тоглоомыг зохион байгуулахад заавал орон байр, хасаа, руллет машин зэрэг биет зүйлс хэрэглэхээ больсон. Энэ нь мөрийтэй тоглоом зохион байгуулагч болон тоглогчийг олж тогтооход хүндрэлтэй болсноор барахгүй мөрийтэй тоглоомд хязгаарлалт тавих, хязгаарлалтын биелэлтийг хангахад хүндрэлтэй болсон.

2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр дараах байдлаар тодорхойлох болсон:

1. Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Мөн түүнчлэн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хуульд өөрчлөлт оруулахдаа мөрийтэй тоглоомыг дэлгэрэнгүй тайлбарлахыг эрмэлзсэн бөгөөд гэмт этгээдийн зорилгыг тусгаж өгсөн. Энэ өөрчлөлтүүд нь гэмт хэргийг зүйлчлэхэд дөхөм болжээ.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж

Монгол улсын эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн тулгуур судлагдахууны нэг бол гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай асуудал юм. Амьдрал, бодит байдал дээр үйлдэгдсэн хэрэг явдал Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг мөн эсэхийг гэмт хэргийн бүрэлдэхүүний тусламжтайгаар шийдвэрлэдэг.

1. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн объект:

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг тогтоох нь тухайн гэмт үйлдэл /эс үйлдэхүй/-д нийгмийн ямар төрлийн эрх ашиг, харилцаа өртсөнийг тодорхойлох боломж олгодог. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанарыг тодорхойлох гол элемент мөн.¹

Уг гэмт хэргийг хууль тогтоогчоос хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан тул гэмт хэргийн объектод хохирол, хор уршиг учирсан байхыг шаардахгүй. Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектыг ерөнхий, төрлийн, шууд гэж ангилдаг.

- Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн ерөнхий буюу нийтлэг объект нь Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан нийгмийн харилцаа байна.
- Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн төрлийн объект нь олон нийтийн аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол байна. Энэ төрлийн харилцаанаас уг гэмт хэргийн шууд объект урган гардаг.
- Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн шууд объект нь мөрийтэй тоглоом зохион байгуулахыг хориглохтой холбоотой хууль тогтоомж байна.

Уг гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт багтдаг. Тиймд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг нь хэн нэгний амь нас, эрүүл мэндэд шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй ч нийгмийн олон төрлийн харилцаанд аюул учруулж байна.

Объект нь: Мөрийнтэй тоглоом зохион байгуулахыг хориглосонтой холбоотой хууль тогтоомж байна².

Мөрийтэй тоглоомын хор нөлөө нь зөвхөн мөнгө алдаад зогсохгүй юм. Мөрийтэй тоглоом нь өөрийгөө үнэлэх байдал, харилцаа холбоо, бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, ажлын гүйцэтгэл, нийгмийн амьдралд нөлөөлдөг. Энэ нь зөвхөн мөрийтэй тоглодог хүнд төдийгүй гэр бүл, найз нөхөд, ажлын байр, нийгэмд хор хөнөөл учруулж болзошгүй юм.

Түүнчлэн сэтгэл зүйчдийн үзэж байгаагаар мөрийтэй тоглоомын донтолт нь хэр удаан хугацаанд тоглож байгаагаас мөн сэтгэлзүйн ямар байдалтай байгаагаас тийм ч их

¹ Гантөмөр.Г.Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.УБ., 2011 он 41 дэх тал.

² С.Гантулга нар “Эрүүгийн эрх зүй” тусгай анги.УБ.,2020 он 292 дах тал.

хамаарахгүй бөгөөд донтолтын суурь үндэс нь хамгийн энгийнээр эхэлж, өөрийн гэсэн бүх зүйлээ алдах хүртэл үргэлжилдэг гэжээ.

Иймд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг нь нийгэмд шууд ямар нэгэн үр дагавар үүсгэхгүй бөгөөд аажимдаа нийгмийн чухал харилцаануудад сөрөг нөлөө үзүүлдэг. Түүгээр ч зогсохгүй мөрийтэй тоглоомд донтсон этгээдүүд мөрийтэй тоглоомыг асуудал гэж үздэггүй. Тэр бүү хэл мөрийтэй тоглоомтой холбогдон шоронд ял эдэлж буй хүмүүсийн 28% нь л мөрийтэй тоглоом бол асуудал гэж үзсэн байна. Тийм ч учраас мөрийтэй тоглоомд донтсон этгээдүүд эмчлүүлсэн ч 70% нь ахин донтдог байна.³

2. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн объектив тал:

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал гэдэг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдаж байгаа нийгмийн харилцаанд /эрх ашиг, сонирхол/ халдсан гэмт этгээдийн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, түүний улмаас учирсан хор уршиг, тэдгээрийн хоорондох шалтгаант холбоо, гэмт хэрэг үйлдсэн, арга, газар, цаг, нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн зэвсэг, хэрэгсэл зэрэг объектив шинжийг агуулсан бүрдэл хэсгийг /элементийг/ хэлнэ.⁴

Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан идэвхтэй үйлдэл байна.⁵

Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоох гол шалгуур нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал юм. Объектив талын шинжүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд хэрхэн хуульчилснаас /тэдгээр нь тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд хэрхэн нөлөөлж байгаагаас/ шалтгаалан:

А. Үндсэн /заавал байх/

Б. Нэмэгдэл /туслах/ шинж гэж 2 ангилна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын заавал байх үндсэн шинжид:

1. гэмт үйлдэл, эс үйлдэхүй
2. гэмт хэргийн хор уршиг
3. шалтгаант холбоо хамаарна.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний объектив тал нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн бүтэцтэй. Хууль тогтоогчоос 2 үйлдлийг уг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр зохицуулсан.

Нэгдүгээрт, мөрийтэй тоглоом зохион байгуулсан үйлдэл.

Хоёрдугаарт, хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан үйлдлээр илэрнэ. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийг эс үйлдэхүйгээр үйлдэх боломжгүй.

Мөрийтэй тоглоом гэж хоёр ба түүнээс дээш тооны этгээдийн хооронд буюу эсхүл тоглоомын газрын зохион байгуулагчаас тогтоосон журмын дагуу түүнтэй байгуулсан

³ Д.Мөнхцэцэг “Донтолт ба сэтгэлзүйн зөвлөгөө” Уб., 2019 он. 151 дэх тал.

⁴ Г.Гантөмөр “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол” Уб., 2011 он. 61 дэх тал.

⁵ .Гантулга нар “Эрүүгийн эрх зүй” тусгай анги. Уб., 2020 он. 292 дах тал.

бөгөөд эрсдэлд үндэслэсэн хонжворын тухай хэлэлцээр юм. Мөрийтэй тоглоомын үр дүн нь мөнгөн буюу бусад эд хөрөнгийн үнэлгээгээр тодорхойлогдоно.⁶

Монгол Улсын хууль, тогтоомжуудад мөрийтэй тоглоомыг нарийвчлан тодорхойлсон тодорхойлолт нь зөвхөн Эрүүгийн хууль байх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журамд мөрийтэй тоглоомыг ангилсан ангилал, шалгуур байхгүй байгаа юм.

Мөрийтэй тоглоом нь олон зуун жилийн түүхтэй бөгөөд үүнийгээ дагаад маш олон төрөлтэй. Монголд хэзрээр мөрийцөх хэлбэрийн (Poker-Texas holdem) тоглоом ихээр тоглогдож байна.⁷ Мөрийтэй тоглоомын бүх хэлбэрийг хуульчлах боломжгүй тул олон улсад мөрийтэй тоглоомыг 2 ангилалд авч үзэн хуульчилдаг. Үүнд:

❖ Chance-based /Тохиолдлын шинжтэй буюу азад суурилсан/

Үр дүн нь санамсаргүй байдлаар гардаг. Тоглогч ялах уу, ялагдах уу гэдэгт нөлөөлж чадахгүй. Бүх тоглогчид ялах боломж ижил байна.

❖ Skill-based /Ур чадварт суурилсан/

Тоглогчийн чадвар эсвэл ур чадвар ялалт, ялагдахад нөлөөлж чадна. Ялах магадлал бүх тоглогчдын хувьд ижил байдаг. Чадвар гэдэг нь "найдвартай бооцоо" гэсэн үг биш юм. Үр дүн нь хэзээ ч тодорхой байж чадахгүй.

Эрүүгийн хуульд заасныг харахад ерөнхийдөө бүх төрлийн мөрийтэй тоглоом зохион байгуулахыг хориглосон боловч Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим нэг хууль тогтоомжид мөрийтэй тоглоомтой холбоотой ойлголтууд үйлчилсэн хэвээр байгаа юм. Жишээлбэл, Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн биет нэгж, тус үйл ажиллагааг эрхлэн явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд онцгой албан татвар ногдуулна.” гэжээ. 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 4.2-д заасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид онцгой албан татвар ногдуулахдаа дараах биет нэгжийг үндэслэл болгоно:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Онцгой албан татвар ногдуулах биет нэгж
1	Тоглоомын ширээ буюу электрон хүрд	1 ширхэг
2	Автомат тоглоом	1 ширхэг
3	Тоглоомын үр дүнг харуулсан касс буюу тотализатор	1 ширхэг
4	Бооцоо тооцоолох букмейкерийн төв	1 ширхэг

6.4 дугаар зүйлд энэ хуулийн 4.2-т заасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр, сард/
1	Тоглоомын ширээ буюу электрон хүрд	116000000
2	Автомат тоглоом	4350000
3	Тоглоомын үр дүнг харуулсан касс буюу тотализатор	116000000
4	Бооцоо тооцоолох букмейкерийн төв	116000000

⁶ С.Нарангэрэл Монгол улсын эрүүгийн эрх зүй. /Тусгай анги/ УБ.,1998 он 267 дахь тал.

⁷ П.Энхчимэг “Мөрийтэй тоглоомын донтолын нийгэм, сэтгэлзүйн шалтгаан” 2012 он 19 дэх тал.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн 7.2.11-т “эд мөнгөний хонжворт сугалаа гаргах, төлбөрт таавар, бооцоот тоглоом тоглуулах үйлчилгээ үзүүлэх” үйлчилгээнд татвар ногдуулахаар заажээ.

Эрх зүйн онолын үүднээс Эрүүгийн хууль болон Онцгой албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиуд нь хууль зүйн хүчин чадлын хувьд тэнцүү тул дээрх хуулиудад дурдагдсан мөрийтэй тоглоомын хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрч байгаа мэт ойлгогдож байна.

Гэмт хэргийн үндсэн шинжид мөрийтэй тоглоом гэж зааж өгсөн бол хүндрүүлэх шинжид хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан гэж зааж өгчээ. Үүнээс харахад үндсэн шинжээр бол бүхий л төрлийн мөрийтэй тоглоомыг хориглож байгаа бол хүндрүүлэх шинжээр зөвхөн казино байгуулахыг хориглосон байна. Учир нь одоогоор зөвхөн казино байгуулахыг л 1999 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан “Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай” хуулиар хориглож өгсөн бөгөөд бусад төрлийн тоглоомын газруудыг хориглосон хууль байхгүй байгаа билээ.

Иймд казино байгуулсан, ажиллуулсан бол хүндрүүлэх шинжээр, харин өөр бусад мөрийтэй тоглоомын газар байгуулж, ажиллуулсан бол үндсэн шинжээр зүйлчлэгдэхээр байна.

Казино гэдэг нь үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан тоглоом тоглуулдаг зориулалтын өрөө, танхим бүхий газрыг, казино тоглоом нь ширээний, слот машин, видео техник хэрэгслийн гэсэн олон төрлүүдтэй.⁸

Уг тодорхойлолтоос харахад казино нь зориулалтын өрөө, танхим бүхий газар байх буюу заавал ямарваа нэгэн байгууламж байхыг шаардахаар тодорхойлж өгчээ. Иймд энэхүү тодорхойлолтоос үзэхэд дараах бодомж урган гарна. Онлайн казино нь Монгол Улсад казино гэсэн ойлголтод хамаарагдахгүй. Гэтэл сүүлийн жилүүдэд интернэт, харилцаа холбооны хэрэгслүүд, виртуал орчин хурдацтай хөгжиж буй. Тиймээс үүнийг дагаад мөрийтэй тоглоом ч мөн адил виртуал хэлбэр лүү шилжин, олон улсад аль хэдийн онлайн казино (интернэт казино, виртуал казино) гэх ойлголт хүчээ авсан байна.

Онлайн казино гэдэг нь уламжлалт казиногийн онлайн хувилбар юм.⁹ Тиймээс дотоод бүтэц нь казинотой ижилхэн байх төдийгүй жинхэнэ казиногоос олон давуу талтай байдаг байна.

Монгол Улсад одоогоор Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлд заасан гэмт хэргээр зүйлчлэгдэн, шүүхээр шийдэгдсэн 27 хэрэг байгаа бөгөөд үүнээс ихэнх тохиолдолд нь харилцаа холбооны хэрэгсэл ашиглан гэмт хэрэг үйлдсэн байна. Гэвч эдгээр нь онлайн казино гэсэн шаардлагыг хангахгүй байгаа юм.

Харин нэг хэрэг нь онлайн казиногийн шаардлагыг хангахуйц бөгөөд мөрийтэй тоглоом тоглоход зориулан сайт нээж 1 тэрбум гаруй төгрөгийг тоглогчдоос хурааж нийт 184.518.668 төгрөгийн ашиг олсон байгаа юм. Шүүхийн шийдвэрт тусгагдсан тухайн сайтад үзлэг хийсэн мөрдөгчийн тогтоолоос харахад уг сайт нь мөрийтэй тоглоом тоглох ширээнүүд үүсгэсэн, тоглож байгаа тоглогчдын тоо, бүртгэл үүсгэсэн хэрэглэгчдийн тоо зэрэг нь харагддаг гэсэн байна. Түүнчлэн уг сайтын үйл ажиллагаа 8 сарын хугацаанд явагдсан боловч 184 сая гаруй төгрөгийн орлого олсон байна. Үйл ажиллагааг нийт 6 хүн нийлэн явуулсан бөгөөд сард олсон орлого нь цалингийн дундаж хэмжээнээс хамаагүй их байгаа юм.

⁸С. Жанцан Эрүүгийн хуулийн тайлбар.УБ.2009 он.

⁹ En.wikipedia.org

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг нь үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүний аль аль нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй учраас уг гэмт хэргээс шалтгаалсан хохирол, хор уршиг учирсан байхыг шаардахгүй. Тийм ч учраас шүүхээр шийдэгдэж буй хэргүүд нь бүгд бусдад төлөх төлбөргүй буюу бусдад хохирол учруулаагүй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл мөрийтэй тоглоом зохион байгуулагчдад тоглогчийн зүгээс өгсөн мөнгийг хохиролд тооцохгүй байгаа юм.

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй тул хэдий хэмжээний орлого олсон нь зүйлчлэлд нөлөөлөхгүй бөгөөд зөвхөн эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээнд л нөлөөлнө.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт үйл ажиллагааны илрэх гадаад хэлбэрийг тодорхойлох обьектив шинжүүдийн нэг бол гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талын нэмэгдэл шинжүүд юм. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдсэн арга
- Гэмт хэрэг үйлдсэн газар
- Гэмт хэрэг үйлдсэн цаг
- Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал
- Гэмт хэрэг үйлдсэн зэвсэг, хэрэгсэл

Тодорхой газар, цаг хугацаанд, нөхцөл байдалд, тодорхой аргаар, тодорхой аргаар, тодорхой зэвсэг, хэрэгсэл ашиглан үйлдэгдэхгүй гэмт хэрэг гэж байдаггүй. Тиймээс гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талын нэмэгдэл шинж нь бүх хэрэгт эрүүгийн эрх зүйн учир холбогдолтой бус юм.

Эрүүгийн хуульд обьектив талын нэмэгдэл шинжүүдийг тодорхой нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэгт тооцох эрүүгийн эрх зүйн гол шинж болох, төсөөтэй гэмт хэргийг ялган зүйлчлэх гол шалгуур нь болж байгаа нөхцөлд л тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүнд хуульчилдаг бөгөөд зөвхөн энэ тохиолдолд л эрүүгийн эрх зүйн учир холбогдолтой болдог.¹⁰

Тэгвэл хууль тогтоогчоос “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэрэгт хэд хэдэн обьектив талын нэмэгдэл шинжийг хуульчилж өгчээ. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдсэн газар /олон нийтийн газар/
- Гэмт хэрэг үйлдсэн хэрэгсэл /мэдээллийн технологи ашиглан, шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан/

Олон нийтийн газар мөрийтэй тоглоом зохион байгуулсан гэж зочид буудал, ресторан, кино театр, бусад үзвэр үйлчилгээний газар болон үйлдвэр, аж ахуйн нэрээр халхавчлан мөрийтэй тоглоход зориулсан автомат машин, тусгай тоног төхөөрөмж бүхий өрөө, тасалгаа, орчныг бүрдүүлж, бусдыг уриалсан байж болно. Мөрийтэй тоглоомын зүйлүүд нь хөзөр, даалуу, галт болон хүйтэн зэвсэг, спортын төрлүүд, биллиард, сугалаат худалдаа зэрэг тоглоомын төрлийг хамааруулж болно.¹¹

Өөрөөр хэлбэл, дээрх газруудад мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх нь Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн болж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.17 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр зүйлчлэгдэнэ. Учир нь мөрийтэй тоглоом зохион байгуулж буй газрын үйл ажиллагаа эрхлэх зориулалт өөр буюу анхлан тус

¹⁰ Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.УБ.2011 он 106 дахь тал.

¹¹ Ж.Авхиа. БНМАУ-ын эрүүгийн эрх зүй /тусгай анги/. УБ., 1979 он 352 дахь тал.

барилга байгуулагдахдаа өөр зориулалтаар баригдсан тул казино гэсэн ангилалд багтахгүй, олон нийтийн газар гэсэн ангилалд харьяалагдана.

3. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн субъект:

Гэмт хэргийн бүрэлдэхүүний заавал байх нэг элемент, эрүүгийн хариуцлага хүлээлгэх субьектив үндэслэл бол гэмт хэргийн бүрэлдэхүүний субьект юм.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектийн үндсэн /нийтлэг/ шинжийг өмнө нь онолын үүднээс тодорхойлж тайлбарладаг байсан. Харин Монгол Улсын шинэ Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үед эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн ба хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектийн үндсэн шинжүүдийг хуульчилсан байна.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектийн үндсэн шинжид хууль тогтоогч дараах 3 шинжийг хамааруулжээ. Үүнд:

1. Хувь хүн байх
2. Эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх
3. Эрүүгийн хуульд заасан насанд хүрсэн байх зэрэг болно. Эдгээрийг иш үндэс болгож Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн субьект хувь хүн байх шинжтэй.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйгээр гэмт хэргийн бүрэлдэхүүний субьект нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн хувь хүн байна. Хувь хүн гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн физиологийн бие, махбод болох тодорхой хүнийг хэлэх ба түүнийг бие хүн гэсэн ойлголтоос ялгах хэрэгтэй.¹²

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн субьект хэрэг хариуцах чадвартай байх ёстой. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдсэн гэмт хэргийнхээ нийгмийн хор аюулын шинж чанар, түүнээс учрах хор аюулын хэр хэмжээг ухамсарлан өөрийн үйлдэлдээ сэтгэцийн хувьд үнэлэлт дүгнэлт өгөх, үйлдлээ удирдан жолоодох улмаар гэмт хэргийн эцэст бий болох үр дагавар буюу эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай байх явдал юм.

Түүнчлэн хэрэг хариуцах чадвартай байдал нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектийн өөр нэг шинж болох субьектийн нас гэсэн ойлголттой салшгүй уялдаа холбоотой. Гэмт хэрэг үйлдсэн этгээд эрүүгийн хуульд заасан насанд хүрч байж гэмт хэргийн бүрэлдэхүүний субьект болдог. Монгол Улсын Эрүүгийн хуульд субьектийн нийтлэг насны доод хязгаарыг 16 нас, цөөн тооны гэмт хэрэгт 14 нас байхаар хуульчилсан. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн хувьд субьект нь 16 насанд хүрсэн байхаар хуульчлагдсан.

Түүнчлэн уг гэмт хэрэгт тусгай субьект шаардагдахгүй.

4. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн субьектив талын шинж:

Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг чухал шинж бол субьектив тал юм. Энэ нь тухайн гэмт хэргийн дотоод агуулгыг бүрдүүлдэг. Гэмт хэргийн субьектив тал гэдэг нь гэм буруутай этгээдээс өөрийн үйлдсэн нийгэмд аюултай үйлдэлд хандсан сэтгэхүйн харьцаа юм.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субьектив тал нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өөрийн гэмт үйл ажиллагаагаа хэрхэн ухамсарлаж хандсан сэтгэхүйн харьцааг тодорхойлох

¹² Г.Гантөмөр. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол.УБ.2011 он 127 дахь тал.

элемент бөгөөд эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд түүнд дараах субъектив шинжүүдийг хамааруулна. Үүнд:

- Гэм буруу
- Гэмт хэрэг үйлдсэн сэдэлт
- Гэмт хэрэг үйлдсэн зорилго
- Гэмт хэрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал зэрэг болно.

Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжүүд болох гэм буруу, гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилго, сэтгэл санааны байдал нь гэмт этгээдээс өөрийн үйл ажиллагаанд хандаж буй харьцааг тодорхой сэтгэхүйн бие даасан үзэгдэл, ойлголтууд боловч хоорондоо харилцан уялдаа холбоотой байдаг.

Гэм буруу гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрүүгийн хуульд заасан өөрийн гэмт үйл ажиллагаа буюу нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй түүний улмаас учрах хор уршгийг хэрхэн ойлгож ухамсарласан сэтгэхүйн харьцааг хэлнэ. Гэмт хэргийн субъектив талын гэм бурууг санаатай ба болгоомжгүй хэлбэр гэж ангилдаг. Мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн субъектив тал нь гэм буруугийн санаатай хэлбэрээр илэрнэ. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд өөрийн мөрийтэй тоглоом зохион байгуулах үйлдлийн нийгэмд аюултай шинжийг ухамсарлаж, түүнийг хүссэн буюу зориуд хийсэн байдаг.

Түүнчлэн, Эрүүгийн хуульд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэргийн субъектив талын нэмэгдэл шинж болох субъектийн зорилгыг “ашиг олох” гэж тодорхой зааж өгсөн байдаг.

Гэмт хэрэг үйлдсэн үндсэн зорилго нь гэмт этгээд гэмт хэрэг үйлдэх явцад хүрэхийг эрмэлзсэн үр дүн мөн.¹³ Профессор С.Жанцан гэмт хэрэг үйлдсэн зорилгыг гэмт этгээдийн хэрэг үйлдээд ирээдүйд хүрч болох үр дүнгийн талаарх төсөөлөл, дүр зураг гэж тодорхойлжээ.¹⁴

Гэмт хэрэг үйлдсэн зорилго нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болгон заасан тохиолдолд субъектив талын заавал байх үндсэн шинж болдог билээ. Тиймд мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг үйлдсэн этгээд ашиг олохыг хүсэж үйлдсэн байхыг шаардана. Өөрөөр хэлбэл, гэмт этгээд ашиг олох зорилгоор мөрийтэй тоглоом зохион байгуулсан эсэхийг заавал тодруулах шаардлагатай юм.

Гэм буруугийн урьдаас төлөвлөсөн шууд санааны үед гэмт этгээд өөрийн хүссэн хор уршгийг учруулснаар түүний гэмт хэрэг үйлдсэн зорилго хэрэгжих ба уг хэрэг нь төгс үйлдэгдсэн гэмт хэрэг болно.

Гэхдээ хууль тогтоогчоос уг гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр тогтоосон тул заавал уг гэмт хэргийн зорилго биелсэн байхыг шаардахгүй. Өөрөөр хэлбэл ашиг олох зорилгоор мөрийтэй тоглоом зохион байгуулах үйлдэл хийхэд л хангалттай бөгөөд ашиг олсон эсэх, эсхүл хэр хэмжээ ашиг олсон бэ гэдэг нь чухал биш юм.

Дүгнэлт

Хүн үүссэн цагаасаа л тоглож наадах, хожиж урамших чухал хэрэгцээтэй байдаг. Тоглох явцдаа өөрийн төлөвшилийг олж авдаг. Тоглоомоороо ямар нэг үнэ бүхий зүйлийг хожно гэдэг нь тэр тоглоомоор дахин тоглох хүслийг төрүүлэх нь гарцаагүй. Мөрийтэй тоглоом нь язгууртны зугаа, ядуусын хоолоо олох арга болох шоогоор эхэлсэн түүхтэй

¹³ С.Нарангэрэл.Монгол улсын ЭЗЗүй. Ерөнхий анги. УБ.,1999 он 182 дахь тал.

¹⁴ С.Жанцан.Монгол улсын ЭЗЗүйн онол. Боть 1. Гэмт хэргийн тухай сургаал. УБ хот., 2010 он 545 дахь тал.

бөгөөд хөгжлийн явцад тоглоомын олон төрөл гарч, магадлалын онол, хөзрийн нууцад үндэслэн дэлхийн хүн амын ихээхэн хэсгийг хамарсан казиног байгуулах хүртэл хөгжсөн билээ.

Мөнгө амьдралын гол хэрэглээ, хэдийгээр мөрийтэй тоглоомоор зугаацах дүрэмтэй боловч тоглосон хэн бүхэн дотроо мөнгө хожих горьдлого найдварыг хадгалдаг. Энэ нь мөрийтэй тоглоомын өөртөө татах нууц мөн. Аливаад хэт автан шунах нь амжилт бус азгүйдлийг авчирдаг гэдгийг түүх бидэнд сануулдаг. Гэвч хүний хүсэл, шунал ханашгүй харин мөрийтэй тоглоом мөнгө хожихыг л санал болгодог чимээгүй тахал. Энэ хоёр хүчин зүйл нийлснээр чөлөөт цагаа өнгөрөөхөөр эхэлсэн тоглоомдоо өөрийн мэдэлгүй донтдог.

Монгол Улсын хувьд хүн ам цөөн, эдийн засгийн хувьд эмзэг, хөгжиж буй улс тул олон нийтийг хамарч болохуйц аюултай үйл ажиллагаануудаас иргэдээ хамгаалахыг зорилго болгодог. Тиймдээ ч бараг бүх төрлийн мөрийтэй тоглоомыг хориглодог.

Хэдийгээр Монгол Улсын эрх зүйн орчин улам бүр сайжирч байгаа хэдий ч иргэдийнхээ амьдралын хэв маягийн хурдацтай өөрчлөлтийг гүйцэхгүй байгаа гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу. Учир нь Монгол Улсын иргэд дэлхийтэй хөл нийлүүлэн алхаж, тэдний хэрэглэдэг бүхий л зүйлийг хэрэглэх болсон. 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” гэмт хэргийг нэг мөр ойлгож хэрэглэж хэрэгцээ шаардлага гарч ирж байна.

Санал

Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйл “Мөрийтэй тоглоом зохион байгуулах” шинээр гэмт хэрэг хэмээн хуульчлахдаа зөвхөн мөрийтэй тоглоом зохион байгуулсан, мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой, харин мөрийтэй тоглоом тоглосон тохиолдолд зөрчлийн тухай хуулийн 4.7 дугаар зүйл “Мөрийтэй тоглоом тоглох” зөрчлөөр зүйлчлэн хариуцлага тооцох боломжтой байна.

Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулиар “Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах, ажиллуулахыг хориглоно”¹⁵ “Казино гэдэг нь рулет, хөзрийн тоглоомын ширээ ба түүнчлэн тоглоомын бусад тоног төхөөрөмжөөр тоноглогдсон мөнгө ба бусад эд хөрөнгийн хонжвор зарладаг мөрийтэй эрхлэн явуулдаг тоглоомын газар, үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй эрсдэл бүхий тоглоом тоглодог зориулалтын өрөө, танхим бүхий газрыг хэлнэ”¹⁶ гэж хууль болон эрдэмтэд казиног тодорхойлсон байна. Тэгтэл сүүлийн үед олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хэдийгээр зохих зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй явагдаж байгаа сугалаа, бооцоот таавар зэргийг хэрхэн зүйлчлэх нь тодорхойгүй байна.

Хувь иргэн, байгууллага цахим хэрэгсэл ашиглан кибер орчинд тодорхой ямар ч хяналтгүй сугалаа явуулж, үр дүнг нь тайлагнахгүй зөвхөн ялагчийг тодруулж байгаа нь нэг талаараа мөрийтэй тоглоом зохион байгуулж давхар залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэж байна. Иймд мөрийтэй тоглоом гэсэн ойлголтыг дэлгэрүүлэн тайлбарлах хэрэгцээтэй байна.

Өөрсдийн санаа бодол нэгдэн мөрийтэй тоглоом хэсэг бүлэг хүн тоглосон тохиолдолд зохион байгуулалтын шинж нь алдагдаж зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авагдаж боломжтой байгаа нь дээрх төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа хүмүүсийн хувьд ял завших бүрэн боломжтой болж байна.

¹⁵ Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хууль. / Төрийн мэдээлэл/ УБ., 1999 он. № 3

¹⁶ С.Нарангэрэл . Эрх зүйн толь бичиг. УБ., 2008 он 243 дах тал